

There are no translations available.

Иргэний хөгжмийн зэмсгийн зэрэгцээ сүм хийдийн хөгжмийн зэмсгийн тусгай торол зүйл олон тоогоор уламжлагдсаар иржээ.

Хөгжмийн зэмсгийн нэлээд торол зүйл нь жинхэнэ монголын гаралтайн зэрэгцээ хорш зэргэлдээх орнуудад тархсан хөгжмийн зэмсэг ч тодорхой байр эзэлнэ. Иргэний хөгжмийн зэмсгийн зэрэгцээ сүм хийдийн хөгжмийн зэмсгийн тусгай торол зүйл олон тоогоор уламжлагдсаар иржээ.

Эхний чавхдаст гурван хөгжмийн нэг нь монгол морин хуурийн торлвуд юм. Овог морин хуурийн жишээнд Ойрад монголчуудад ихэд дэлгэрсэн икэл, бас буриадуудын дунд уламжлагдан ирсэн суух хуурыг оруулж болно.

Мон Хятад, Солонгос, Япон зэрэг орнуудад оргон тархсан хуучир, бийваа, бийвлэг, шанз (шудрага) зэрэг чавхдаст хөгжмийн зэмсгүүд байна. Чавхдаст хөгжмийн зэмсгийн оор нэгэн торол хэвтээ ятга, ёочин зэргийг дурьдаж болно.

Эдгээр нь Монголд буй хөгжмийн зэмсгийн нэлээд нь шашны хурал ном, ялангуяа шашны том жижиг ёслол, зан вйл, цам бvжгийн вед тоглодог байсан хөгжмийн зэмсгүүд болно.

Тухайлбал, заавал хосолж влээдэг цордон бvрээ, дамар, хэнгэрэг, мон бялар (бишгvвр) зэргийг нэрлэж болно. Эдгээр нь влээвэр, цохивор хөгжмийн зэмсгийн торлвуд юм.

Үлээвэр хөгжмийн бусад торлвүдээс гэвэл урт богино лимбэ, бас ойрад-баруун монголд ихэд тархсан цуур (цоор)-ыг нэрлэж болно.

Энд хамгийн сонирхолтой хөгжмийн зэмсэг нь монголд эрт вeэс уламжилж ирсэн, монгол гарлын овормоц дуу аялгуутай иргэний хөгжмийн зэмсэг болох цуур юм.

Цуур нь гурван нvхтэй, шvд, уруулийн оролцоотойгоор дуугардаг, модыг хоёр тал гуурслан ухаад хооронд нь утсаар ороож гадуур нь хонины улаан хоолой, эсвэл олон гэдэс углаж хатааж хийдэг байна. Цуур (цоор)-ын татлага гэж 30 гаруй аялгуу байдаг хэмээн судлаачид тэмдэглэсэн байна.

Хөгжмийн зэмсгийн дараагийн торол зvйлд дуударам, том жижиг цан, сэлнэн, дэншиг, гандан, дун зэрэг цохивор, влээвэр хөгжмийн зэмсгүүд хамаарна.

Эдгээр нь голдуу сүм хийдийн газраа шашны янз бvрийн ёслол, зан вйлийн вед тоглодог зэмсгүүд болой.

Иргэний болон сүм хийдийн хөгжмийн зэмсгүүд нь эдвгээ монголын вндэсний найрал хөгжимд (оркестрт) оргон ашиглагдах болсон.